

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой түлш ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/028/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэлийн Аудитын газрын дарга М.Эрдэнэжаргал Утас: 261663 Цахим хаяг: erdenejargalm@audit.gov.mn Нийслэлийн Аудитын газрын дэд дарга Ч.Болд Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarch@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 260512 Цахим хаяг: yansanjavya@audit.gov.mn Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 976-99115395 Цахим хаяг: info@niislelaudit.mn Аудитор: Л.Сарантуяа Утас: 976-99118839 Цахим хаяг: l.sarantuya@niislelaudit.mn</p>
---	---



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Утас: 03.14 № 01/336
танай _____ -ны № _____ -т

ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ЭРДЭНЭБАЯР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой түлш ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сайжруулсан шахмал түлшний түүхий эд 23.3 мянган тонн барьцалдуулагчийг 65,372.6 сая төгрөгөөр сонгон шалгаруулалтгүйгээр худалдан авсан, байгууллагын агуулахад 120.8 сая төгрөгийн чанар нь муудсан 161.5 тонн гурил хадгалагдаж, санхүүгийн бүртгэлд хөрөнгөөр тусгагдаж байгаа зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Үнэн зөв, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Таван толгой түлш ХХК нь сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулах ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Баруун үйлдвэрийг татан буулгаж Зүүн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр үйлдвэрлэлийн 20 шугамаар дамжуулан үйлдвэрлэж байсан шахмал түлшийг 5 шугамаар үйлдвэрлэх боломжтой болж, бүтээгдхүүний өртөг 30 хувиар буурах боломжтой болсон.

- 22.5 Мвт хүчин чадал бүхий Дулааны станцыг шинээр барьж ашиглалтад оруулснаар зүүн үйлдвэрийн 22 объектийг нэгдсэн сүлжээнд оруулж дулаанаар хангах эх үүсвэр бүрдсэн.

Аудитын гол асуудал

Тайлант онд 510.6 мян.тн сайжруулсан шахмал түлш нэмж үйлдвэрлэснээс 511.8 мян.тн-ыг 76,767.3 сая төгрөгөөр борлуулж, үйл ажиллагааны бус орлогоос 2,334.2 сая төгрөг, нийт 79,101.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 306,801.1 сая төгрөгийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал гарган 227,737.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийслэл хотын агаарын чанарыг сайжруулах төрийн бодлогын хүрээнд тус компанийн үндсэн үйлдвэрлэл болох сайжруулсан шахмал түлшний 1 тонныг борлуулах үнийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/12 тоот тогтоол, шийдвэрийн дагуу 150.0 мянган төгрөгөөр 2019 оноос хойш тогтмолоор мөрдөж байгаа бөгөөд энэ нь түлш үйлдвэрлэлийн нэгж тонны өртгөөс 4 дахин бага байгаагаас байгууллагын нийт зардлын 80 хувийг Эрдэнэс тавантолгой ХК-ийн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Тавантолгой түлш ХХК нь 1,348,510.0 сая төгрөгийн санхүүжилтийн зээлийн өглөгтэй байна.

Тавантолгой түлш ХХК-ийн төрийн эзэмшлийн хувийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай Монгол Улсын Их хурлын 2024 оны 07 дугаар тогтоол гарсан боловч тайлант хугацаанд төрийн өмчлөлийн хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй байна.

Бусад асуудал

Тавантолгой түлш ХХК нь 2024 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 13 зорилтын хүрээнд 136 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 85.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendeme\Desktop\2025\Word\Yvaan_bichig\2025.03.15.Tavantolgoi_tulsh.docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	24,177,426,624.94	10,607,024,659.48
1.1.2	Дансны авлага	865,171,960.39	2,013,164,967.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	4,510,080.00	-
1.1.4	Бусад авлага	71,957,645.00	141,352,500.00
1.1.6	Бараа материал	98,094,470,429.90	111,703,647,904.43
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	35,670,828,204.27	29,210,997,126.82
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	158,884,364,944.50	153,676,187,158.04
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	256,161,468,142.84	239,129,086,802.46
1.2.2	Биет бус хөрөнгө	4,519,684,610.75	6,729,437,119.75
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		61,009,483,552.24
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	260,681,152,753.59	306,868,007,474.45
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	419,565,517,698.09	460,544,194,632.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	20,935,811,943.23	14,731,139,456.83
2.1.1.2	Цалингийн өглөг	33,867,834.09	82,175,781.84
2.1.1.3	Татварын өр	1,038,503,784.30	1,296,453,877.21
2.1.1.4	НДШ-ийн өглөг	119,320,775.46	26,241,485.04
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,821,130,670.10	801,499,743.84
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	787,772,890.73	136,951,531.73
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	169,599,520.28	721,751,984.7
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,906,007,418.19	17,796,213,861.19
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,067,296,527,463.41	1,348,509,964,167.14
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,067,296,527,463.41	1,348,509,964,167.14
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,093,202,534,881.60	1,366,306,178,028.33
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	1,000,000.00	1,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(673,638,017,183.51)	(905,762,983,395.84)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(673,637,017,183.51)	(905,761,983,395.84)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	419,565,517,698.09	460,544,194,632.49

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	77,817,956,250.00	76,767,251,250.00
2	Борлуулалтын өртөг	247,310,825,594.58	251,852,614,535.72
3	Нийт ашиг (алдагдал)	(169,492,869,344.58)	(175,085,363,285.72)
5	Хүүгийн орлого	713,209,091.14	381,325,081.85
8	Бусад орлого	3,221,815,868.94	1,952,913,050.77
9	Борлуулалт, маркетингийн зардал	13,462,104,693.14	5,273,771,316.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	37,925,497,836.95	44,263,979,001.35
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	982,401,967.57	3,357,046,197.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(38,721,564.37)	(140,196,847.42)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(1,913,477,214.64)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(217,966,570,446.53)	(227,699,595,729.94)
19	Орлогын татварын зардал	71,318,487.70	38,132,508.19
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(218,037,888,934.23)	(227,737,728,238.13)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(218,037,888,934.23)	(227,737,728,238.13)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	(447,115,626,471.16)	(447,114,626,471.16)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(8,484,501,778.12)	(8,484,501,778.12)
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	(455,600,128,249.28)	(455,599,128,249.28)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(218,037,888,934.23)	(218,037,888,934.23)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	(673,638,017,183.51)	(673,637,017,183.51)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(4,387,237,974.2)	(4,387,237,974.2)
11	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	(678,025,255,157.71)	(678,024,255,157.71)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(227,737,728,238.13)	(227,737,728,238.13)
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	(905,762,983,395.84)	(905,761,983,395.84)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	77,697,997,600.57	76,456,579,949.15
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	77,604,961,618.00	76,306,265,050.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	93,035,982.57	150,314,899.15
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	304,859,130,485.82	327,479,731,947.71
1.2.1	Ажиллагчдад төлсөн	73,481,732,300.03	65,992,465,440.62
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,993,949,440.05	19,701,186,707.77
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	110,756,098,259.50	123,705,393,887.06
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,998,492,072.91	4,001,241,092.05
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	40,290,523,922.36	62,878,046,867.73
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	15,223,025,602.54	7,236,327,586.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,115,308,888.43	43,965,070,366.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(227,161,132,885.25)	(251,023,151,998.56)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	713,209,091.14	381,325,081.85
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	713,209,091.14	381,325,081.85
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	29,567,879,448.63	43,741,333,110.71
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	12,980,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	29,567,879,448.63	43,728,353,110.71
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(28,854,670,357.49)	(43,360,008,028.86)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	265,430,635,263.72	280,979,457,800.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	265,430,635,263.72	280,979,457,800.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	265,430,635,263.72	280,979,457,800.00
4	Валютын ханшийн зөрүү	(51,640,243.48)	(166,699,738.04)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,363,191,777.50	(13,570,401,965.46)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,814,234,847.44	24,177,426,624.94
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,177,426,624.94	10,607,024,659.48

2.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 он		Өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	%
ХӨДӨЛМӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ					
Нийт ажилчдын тоо /дундаж/	Мян хүн	1,900	1,823	(77.00)	95.9%
Цалингийн сан	сая.төг	82,123.3	79,226.0	(2.897.3)	96.5%
Сарын дундаж цалин	сая.төг	3.6	3.6	0.0	100.5%
ТҮҮХИЙ ЭДИЙН ТАТАН АВАЛТ					
Миддлинг	мян.тн	595.0	520.0	(75.0)	87.4%
Барьцалдуулагч	мян.тн	28.0	23.3	(4.7)	83.3%
Сав баглаа боодол	сая.ш	21.0	24.5	3.5	116.7%
ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТ.НИЙ ТОО		556.8	510.56	(46.2)	91.7%
Баруун үйлдвэр	мян.тн	76.8	70.9	(5.9)	92.3%
Зүүн үйлдвэр	мян.тн	319.2	255.9	(63.3)	80.2%
Төвийн үйлдвэр	мян.тн	160.8	183.8	23.0	114.3%
ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТ.НИЙ ӨРТӨГ	мян.төг/тн	476.1	491.2	15.1	103.2%
Баруун үйлдвэр	мян.төг/тн	508.9	471.3	(37.5)	92.6%
Зүүн үйлдвэр	мян.төг/тн	511.1	546.2	35.1	106.9%
Төвийн үйлдвэр	мян.төг/тн	461.0	422.3	(38.7)	91.6%
БОРЛУУЛСАН БҮТ.НИЙ ТОО	мян.тн	528.0	511.8	(16.2)	96.9%
БОРЛУУЛСАН БҮТ.НИЙ ҮНЭ	мян.төг	150.0	150.0		100.0%
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.₮	79,200.0	76,767.3	(2,432.7)	96.9%
БОРЛУУЛСАН БҮТ.НИЙ ӨРТӨГ	сая.₮	248,737.4	251,852.6	3,115.2	101.3%
Борлуулалтын орлого	сая.₮	79,200.0	76,767.3	(2,432.7)	96.9%
Нийт ашиг, алдагдал	сая.₮	(169,537.4)	(175,085.4)	(5,547.9)	103.3%
Үйл ажиллагааны бус бусад орлого	сая.₮	433.0	2,334.2	1,901.3	539.1%
Удирдлагын зардал	сая.₮	55,363.6	47,621.0	(7,742.5)	86.0%
Борлуулалтын зардал	сая.₮	4,190.0	5,273.8	1,083.8	125.9%
Бусад зардал	сая.₮	-	2,053.7	2,053.7	0.0%
Татварын өмнөх ашиг	сая.₮	(228,658.0)	(227,699.6)	958.4	99.6%
Татварын зардал	сая.₮	-	38.1		0.0%
Цэвэр ашиг	сая.₮	(228,658.0)	(227,737.7)	1,430.9	99.4%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.₮	64,980.0	46,186.9	(18,793.1)	71.1%
Нийт авлага	сая.₮	446.1	1,663.4	1,217.3	372.9%
Богино хугацаат өр төлбөр	сая.₮	24,493.9	17,796.2	(6,697.7)	72.7%
Урт хугацаат өр төлбөр	сая.₮	1,356,276.0	1,348,510.0	(7,766.0)	99.4%
Санхүүжилт	сая.₮	288,979.5	280,979.5	(8,000.0)	97.2%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,500.7 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Аудитын зөвлөмжийн дагуу ажилтнуудад дутуу олгосон цалинг нөхөж олгох арга хэмжээ авсан боловч ажлаас гарсан ажилтнуудад өгөх ёстой байсан дутуу цалингийн 48.1 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулж өглөгөөр тусгасан,
- Тавантолгой түлш ХХК болон Мару ичи стар ХХК-ийн хооронд Монголын төмөр зам ашиглалтыг дамжуулан түрээслэх тухай 2024 оны ТТТ-2024-288 тоот гэрээний дагуу Мару ичи стар ХХК-иас хүлээж авсан орлого болон Монголын төмөр замд төлсөн ачаа тээврийн зардлын дүнг санхүүгийн тайланд тусгаагүй, авлага, өр төлбөрийн тооцооны дансаар дамжуулан хаасныг залруулж, 1,286.5 сая төгрөгийн түрээсийн орлого болон тээврийн хөлсний зардлыг нөхөж бүртгэсэн,
- “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ болон “Тавантолгой түлш” ХХК-ийн хооронд байгуулсан 2020 оны ЭХХТ/67/2020 тоот барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих гэрээний дагуу ажлын гүйцэтгэлд олгосон 13.7 сая төгрөгийг урьдчилгаа тооцоо дансанд бүртгэснийг залруулж, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн.
- Байгууллагын захиалгаар хийгдэж гүйцэтгэгчээс хүлээн авсан 152.4 сая төгрөгийн үнэ бүхий барилгын зургийн үнийг шүүхийн шийдвэрийн дагуу гүйцэтгэгчид төлснийг буцааж авах авлагаар бүртгэснийг залруулж биет бус хөрөнгөөр бүртгэсэн.

Аудитаар нийт 65,493.4 сая төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 1 зөвлөмж 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 65,493.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 63,999.9 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 АЛБАН ШААРДЛАГА

Тус компанийн 2020-2021 онуудад сайжруулсан шахмал түлшний барьцалдуулагчийг орлуулж хэрэглэхээр худалдан авсан Алтан тариа үйлдвэрийн 2 дугаар зэргийн гурил нь үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэгдээгүй, тайлант оны эцэст нийт 161.1 мянган тонн үлдэгдэлтэй, 120.8 сая төгрөгийн үнэтэйгээр бараа материалын дансанд бүртгэгдэн байгууллагын агуулахад хадгалагдаж байна. Энэхүү гурил нь үйлдвэрлэл болон хүнсэнд хэрэглэгдэх чанарын шаардлага хангахгүй болсон нь шинжилгээгээр тодорхойлогдож хөрөнгийн шинж чанараа алдсан боловч бараа материалын бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “оршин байх” болон “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Агуулахад байгаа цаашид хэрэгцээ шаардлага хангахгүй болсон материалыг устган данс бүртгэлээс хасаагүй, хуулийн байгууллагын шийдвэрийг эцэслэж аваагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих Зардлын данстай холбоотой асуудлын талаар

Тайлант онд "Гарааны баргил тех" ХХК, "Хангай хан өндөр" ХХК, "Барилт трейд" ХХК-иудын нэгдэж байгуулсан концерциумтай 19,530.0 сая төгрөгийн ТТГ-2024-152 тоот гэрээ, Хятад улсын "Жуншин шинэ материал технологи" ХХК-тай 45,842.6 сая төгрөг

(84.5 сая юань)-ийн ТТТ-2024-Н01 тоот гэрээг тус тус байгуулж сайжруулсан шахмал түлшний барьцалдуулагчийг нээлттэй тендер зарлалгүйгээр нийт 65,372.6 сая төгрөгөөр шууд худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д "Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 35.1.2-д "онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй" нөхцөлд шууд худалдан авалт хийнэ гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах зөвлөмж өглөө.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруула агүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сайжруулсан шахмал түлш галт тэргээр тээвэрлэлт хийгдэхгүй байх хугацаанд Монголын төмөр зам ашиглалтыг дамжуулан түрээслэх гэрээний дагуу олсон орлого болон зардлын дүнг санхүүгийн тайланд тусгаагүй, авлага өглөгийн тооцооны данс дамжуулан хаасан	1	1,286,510.6			1	1,286,510.6	1	1,286,510.6				
2	Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих гэрээний дагуу гүйцэтгэлд олгосон гэрээний үнийг урьдчилгаа тооцоо дансанд бүртгэсэн.	1	13,684.4			1	13,684.4	1	13,684.4				
3	Ажлаас гарсан ажилтнуудад өгөх ёстой байсан цалингийн дүнг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	48,164.4			1	48,164.4	1	48,164.4				
4	Компанийн захиалгын дагуу хийлгэж хүлээж авсан барилга угсралтын ажлын зураг төсвийн үнийг шүүхийн шийдвэрийн дагуу Гүйцэтгэгчид төлснийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн.	1	152,395.9			1	152,395.9	1	152,395.9				
	Дүн	4	1,500,755.4			4	1,500,755.4	4	1,500,755.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
1	Үйлдвэрлэлд хэрэглэхээр худалдан авсан 161.1 мянган тонн Алтан тариа гурилын үйлдвэрлэл болон хүнсэнд хэрэглэгдэх чанарын шаардлага хангахгүй болсон нь шинжилгээгээр тодорхойлогдож хөрөнгийн шинж чанараа алдсан боловч бараа материалын бүртгэлээс хасаагүй байна.	1	120,840.6			1	120,840.6							
2	Сайжруулсан шахмал түлшний барьцалдуулагчийг нээлттэй тендер зарлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн.	1	65,372,600.7			1		1	65,372,600.7					
3	Дүн	2	65,493,441.3			1	120,840.6	1	65,372,600.7					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Хөдөлмөрийн дотоод журам, цалин тооцох журмын дагуу сар бүр компанийн үйлдвэрлэлийн ажилтнуудад үндсэн цалингийн 40 хувь, конторын ажилтнуудад 20 хувийн урамшууллыг нийт ажилтнуудын 99-100 хувьд олгосны дараа улирлын сүүлийн сарын цалин дээр нийт ажилтнуудад дахин 60 хувийн урамшууллыг давхардуулан олгож байна. Мөн Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагатай Хамтын гэрээ байгуулаагүй, цалин тооцох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах тухай аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна	1	7,415,866.4	1	7,415,866.4		
2	Тавантолгой түлш компанийн байгууллагын үндсэн үйлдвэрлэл болох сайжруулсан шахмал түлшний үндсэн орц норм, үйлдвэрлэлийн техник технологитой холбоотой баримт бичгүүд, сайжруулсан шахмал түлшний барьцалдуулагчийн худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг үндэслэлгүйгээр байгууллагын Нууцын зэрэглэлд оруулсан.	1	-	1	-		
3	Босго үнээс дээш үнэтэй зарим нэр төрлийн барилгын угсралтын болон их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлахдаа барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тооцоолж гаргаагүй, ажлын гүйцэтгэлийн мөнгөний бодит зарцуулалтанд хяналт хийгээгүй.	1	9,026,738.8	1	9,026,738.8		
	Дүн	3	16,442,605.2	3	16,442,605.2		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 419/14025245

Улаанбаатар хот

НТАГ-2025/028/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой түлш ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Сайжруулсан шахмал түлшний барьцалдуулагчийг орлуулж хэрэглэхээр 2020-2021 онуудад худалдан авсан Алтан тариа үйлдвэрийн 2 дугаар зэргийн гурил нь үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэгдээгүй, тайлант оны эцэст нийт 161.1 мянган тонн үлдэгдэлтэй, 120,840,620.00 (нэг зуун хорин сая найман зуун дөчин мянга зургаан зуун хорь) төгрөгийн үнэтэйгээр бараа материалын дансанд бүртгэгдэн байгууллагын агуулахад хадгалагдаж байна. Энэ нь үйлдвэрлэл болон хүнсэнд хэрэглэгдэх чанарын шаардлага хангахгүй болсон нь шинжилгээгээр тодорхойлогдож хөрөнгийн шинж чанараа алдсан боловч бараа материалын бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.6-т "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх, ийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Агуулахад байгаа цаашид хэрэгцээ шаардлага хангахгүй болсон материалыг устган данс бүртгэлээс хасаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, ерөнхий нягтлан бодогч С.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Т.СУГАРСҮРЭН

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1100040187



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 417/14025245

Улаанбаатар хот

ИТЯГ-2025/028/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой түлш ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төрийн нууцын тухай хуулийг зөрчиж Гүйцэтгэх захирлын 2024 оны А/239 дугаар тушаалаар Таван толгой түлш ХХК-ийн үндсэн үйлдвэрлэл болох сайжруулсан шахмал түлшний үндсэн орц норм, үйлдвэрлэлийн техник технологитой холбоотой баримт бичгүүд, сайжруулсан шахмал түлшний барьцалдуулагчийн худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг үндэслэлгүйгээр компанийн Нууцын зэрэглэлд оруулсан байна.

Энэ нь Нууцын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1-т "Тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологи нь хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол байгууллага уг мэдээллийг нууцалж болохгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь**:

1.Нийслэл хотын агаарын чанарын үзүүлэлтэд нөлөөлөхүйц үйлдвэрлэл болох сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэлийн түүхий эдийн орц норм технологи болон барьцалдуулагчийн худалдан авалтын мэдээллүүдийг байгууллагын нууцын зэрэглэлд оруулсан зөрчлийг зогсоож биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, ерөнхий нягтлан бодогч С.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

Т.СУГАРСҮРЭН

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

14025240471



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 416/14025245

Улаанбаатар хот

ИТАГ-2025/028/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Таван толгой түлш ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус компани нь албан ёсны баталгаажсан барилга угсралтын ажлын зураг төсөл, төсөв гаргалгүйгээр нийт 9,026,738,800.00 (есөн тэрбум хорин зургаан сая долоон зуун гучин найман мянга найман зуун) төгрөгийн үнийн дүн бүхий 33 нэр төрлийн ажлыг тендер зарлан хийж гүйцэтгүүлсэн ба их засварын ажлын хөрөнгийн бодит зарцуулалтад нарийн хяналт тавиагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 279 тоот тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам, 3 дугаар зүйл 3.2.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй", 3.2.2.2-т "Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх"; Төрийн хэмнэлтийн тухай хууль 13 дугаар зүйл 13.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад... зураг төсөв нь батлагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажлын зураг төсөл, төсвийг гаргахгүйгээр барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа зөрчлийг зогсоож, биелэлтийн нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, ерөнхий нягтлан бодогч С.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

ХЯНАСАН

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Т.СУГАРСҮРЭН

Я.АЛТАНЦЭЦЭГ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

14025245



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 418/14025245

Улаанбаатар хот

УТАГ - 2025/028/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Таван толгой түлш ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам, цалин тооцох журмын дагуу нийт ажилтнуудад сар бүр үндсэн цалингаас тооцон 20-40 хувийн урамшуулалт цалин олгож байгаа боловч улирлын сүүлийн сард дахин 60 хувийн улирлын урамшууллыг сар бүрийн урамшуулал дээр давхардуулан олгож байна. Тайлант онд нийт 7,415,766,440.00 (долоон тэрбум дөрвөн зуун арван таван сая долоон зуун жаран зургаан мянга дөрвөн зуун дөч) төгрөгийн улирлын урамшуулал олгосон бөгөөд цалин тооцох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай Хамтын гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 15 дугаар зүйл 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" 15.2.6-т "Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" Хөдөлмөрийн тухай хууль 12 дугаар зүйл 12.1-т "Ажил олгогч, ажил олгогчийн төлөөлөгч хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах зорилгоор ажилтны төлөөлөгчтэй хамтын хэлэлцээ хийх, ажилтантай харилцан тохирч хөдөлмөрийн гэрээ, түүнийг дагалдах гэрээг байгуулах бөгөөд хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцааны асуудлаар хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тогтоох эрхтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11."хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Холбогдох хуульд нийцүүлэн цалин урамшуулал олгох журмыг шинэчлэн боловсруулаагүй, Үйлдвэрчний эвлэлийн хороотой Хамтын гэрээ байгуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

1425040489

2.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, ерөнхий нягтлан бодогч С.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Т.СУГАРСҮРЭН

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР



Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар